

ЭРДЭНЭ РЕСУРС 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2022.05.12

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь 2022 оны 3 сарын 31-нд дуусгавар болсон нэгдүгээр улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Хөндий Алт Дүүрэг ба Баян Хөндий Алтны Төслийн ("Баян Хөндий" эсвэл "БХ") хөгжүүлэлтийн мэдээлэл хүргэж байна. SEDAR болон компанийн вебсайт дээр байршуулсан 2022 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" буюу "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ") нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Бид 2022 оны эхний улиралд Баян Хөндий Алт Төслийн хөгжүүлэлт, Хөндий Алтны Дүүргийг тэлэх зорилтын дагуу амжилттай ажилласан. Бид 2022 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн эхний үе шатыг эхлүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрөөр 2021 онд нээн илрүүлсэн Хар Морийн Дэл болон Зүүн өмнөд Улаан талбайг үргэлжлүүлэн шалгана. Дээрх нээлтүүд нь Эрдэнэ Ресурсийн Хөндий дүүргийн тренд олон сая унц алтны нөөц агуулах боломжтой хэмээх таамаглалыг дэмжиж байгаа бөгөөд Баян Хөндий Алтны Төслийн олборлолтыг нэмэгдүүлэх боломжтой."

"Бид Ковид-19 цар тахлаас үүссэн тодорхойгүй байдлуудыг үл харгалзан Баян Хөндийн бүтээн байгуулалтын шийдвэрийг гаргахад зориулж бэлтгэл ажлуудыг тууштай ахиулж байна. Бүтээн байгуулалтын шийдвэр гаргахаас өмнө инженерчлэл болон зураг төслийн ажлуудыг гүйцэтгэж, худалдан авалтын ажлуудыг ахиулан ажилласан. Мөн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн эхлүүлэхээс өмнө олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зураг төслийг эхлүүлсэн."

2022 оны нэгдүгээр улирлын онцлох үйл явдлууд:

Хөндий Алтны Төсөл - Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшил

- Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын явц:
 - Кемпийн өргөтгөл, харилцаа холбооны дэд бүтцийн суурилуулалт, төслийн хяналтын програм хангамжийн хэрэгжилт зэрэг бэлтгэл ажлуудыг дуусгасан

- Голлох механик болон барилгын ажлын тендер, өртгийн дахин тооцооллыг гүйцэтгэж байгааг 2022 оны 2-р улиралд эцэслэнэ.
- Инженерчлэл, худалдан авалт болон угсралтын менежмент, түүнчлэн ажилчдын хотхон, агуулах, засвар үйлчилгээний байгууламж зэрэг боловсруулах үйлдвэрээс бусад дэд бүтцийн боломжит борлуулагч талуудыг тодорхойлсон.
- Барилга угсралтын шийдвэр гаргахаас өмнө үндсэн ажилтнууд, төслийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гарын авлагыг бэлтгэсэн
- Уурхайн ус хангамжийг баталгаажуулах судалгааг эхлүүлсэн бөгөөд үр дүн нь 2022 оны 2-р улирлын эцэст гарна.
- Уурхайн хөгжүүлэлтийг эхлүүлэхэд шаардлагатай захиргааны байгууллагуудын зөвшөөрлүүдийг авч байна:
 - Анхан шатны бүтээн байгуулалт болон байгууламжийн нарийвчилсан зураг төслийн хяналт амжилттай гүйцэтгэж байна, есөн байгууламжийн зураг төсөл батлагдсан бөгөөд 2022 оны 2-р сард эдгээрийн 8 барилга, байгууламжийн барилгын зөвшөөрөл авсан
 - Баяжуулах үйлдвэрийн хяналтын ажлууд үргэлжилж байгаа бөгөөд 2022 оны 3-р улиралд батлуулахаар төлөвлөж байна.
- Орон нутгийг дэмжих хөтөлбөрүүд үргэлжилж байна:
 - Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.
 - 2022 оны хоёрдугаар улиралд бүтээн байгууллагын бэлтгэл ажлын шийдвэр гарахаас өмнө орон нутагт 30 орчим ажлын байр шинээр бий болгосон.
 - Ирээдүйн нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд 2 га талбайд ургамалжуулах хөтөлбөрийг эрчимжүүлсэн.

Хайгуулын хөтөлбөр

- Хөндий Алтны Дүүргийн 2022 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн эхний үе шат нь 10,000 метрийн алмазан өрөмдлөгөөр эхлэн, 4 сараас 3,000 метрийн RAM өрөмдлөгөөр үргэлжилнэ. Эхний үе шат нь 2-р улирлын турш үргэлжилнэ. Эхний үе шатны үр дүнгүүдэд тулгуурлан дараагийн үе шатны хөтөлбөрийг загварчлахаар төлөвлөсөн.
- Энэхүү хайгуулын хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий исэлдсэн алтны бүсүүдийг судлан, Алтан Нар алтны төслийн үргэлжлэл, 2021 онд нээн илрүүлсэн Баян Хөндий алтны төсөл (“Баян Хөндий”)-ийн Хар Морь болон Улаан нээлтийн өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийг тэлэх зорилготой.
- Өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгүүдийг 2022 оны 5-р сарын сүүлээр танилцуулна.

Компанийн тухай

- Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай Баян Хөндий Алтны Төслийн санхүүжилттэй холбоотой нарийвчилсан судалгааг гүйцэтгэж байна.

- \$55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичигт гарын үсэг зурсан.
 - 2022 оны хагас жилд эцэслэхээр зээлийн нөхцөл болон баримт бичгийг боловсруулах ажлуудыг гүйцэтгэж байна.
 - Дээрх үйл ажиллагаатай зэрэгцэн нэмэлт зээлийн судалгааг Монгол Улсын санхүүгийн байгууллагууд гүйцэтгэж байна.
- 2022 оны 3 сарын 31-ний өдөр дуусгавар болсон нэгдүгээр улирлын эцэст Компанийн нийт алдагдал \$1,231,156 байсан ба 2021 оны мөн үед \$617,084 байв.
 - Капиталжуулсан зардал \$2,122,948 оролцуулсан хайгуул болон үнэлгээний өртөг нь 2022 оны 3 сарын 31-ний байдлаар \$2,904,572 байсан нь 2021 оны мөн үеийн капиталжуулсан зардал \$2,289,725 оролцуулсан \$2,523,968-тай харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Баян хөндий алтны төслийн нарийвчилсан инженерчлэл, загварчлалын судалгаа, бүтээн байгуулалтын бэлтгэх (урт хугацааны худалдан авалтын урьдчилгаа зэрэг) гэх ажлууд нэмэгдсэнтэй холбоотойгоор зардал харьцуулсан үеийнхээс давсан байна. Мөн оролцогч талуудтай хамтран ажиллах зардлууд өссөн нь 2021 онд Баян Хөндий алтны төслийн орон нутгийн захиргааны байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ (“LCA”)-г байгуулсантай холбоотой.
 - Компанийн захиргаа, удирдлагын зардал нь 2022 оны 3 сарын 31-ний байдлаар \$445,446 байсан нь 2021 оны мөн үеийн \$394,604-тай харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Энэ нь Баян Хөндий алтны төслийн бүтээн байгуулалтын болон санхүүжилтийн хүрээнд захиргааны цалин, компанийн зах зээлийн үнэлгээний өсөлтөөс шалтгаалсан зохицуулалтын хураамж нэмэгдсэнтэй холбоотой.

Мэргэшсэн этгээд (геологич)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба хэвлэлийн мэдээг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Орчуулга: Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>